



Б Н М А У

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 12 сарын 09

№ 338

Улаанбаатар хот

"Дэлгэрэх" компани /УҮГ/  
байгуулах тухай

БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн тухай хуулийг үнцэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Хотын хэлцэлийн худалдааны "Дэлгэрэх" нүүсийг 1991 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөр тасалбар болгон татан буулгаж, "Дэлгэрэх" компани /УҮГ/-ийг хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны харъяанд ажиллуулсугай.

2. "Дэлгэрэх" компани /УҮГ/-ийн дүрмийг 1 дүгээр хавсралтаар, "Дэлгэрэх" компанийн салбар цэлгүүрт бараа худалдаалах дүрмийг 2 дугаар хавсралтаар, сард мөрдөх цалингийн нийт санг 98,0 мянган төгрөгөөр тус тус баталсугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хэлцэлийн худалдаа" нүүс байгуулах тухай хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 96 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-  
ГААНЫ ДАРГА

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА

Д.ЭНЭБИШ

Ц.БОЛДСАЙХАН



ГӨЛМӨТӨХ УЛААНБААТАР ХОТИЙН АРШЫН ХУРЛЫН  
ЗАСГАГАА ГҮЙЦЭГТЭХ ЗАХИРГААНЫ 1991 ОНЫ  
338 ДУГААР ТОГТООЛЫН I ДҮГЭЭР  
ХАВСРАЛТ

ХУДАЛЦАА ЗУУЧЛАЛ ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛ-  
ГЭЭНИЙ "ДЭЛГЭРЭХ" КОМПАНИЙН ДҮРЭМ  
/УҮГ/

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Компанийн нэр "Дэлгэрэх" компани /УҮГ/
2. Оршин байх газар, хаяг: "Дэлгэрэх" компани /УҮГ/. Октяб-  
рийн дүүргийн 25-р хороо, IV хороолол, утас 63119, 61827
3. Компани нь дараах ажил үйлчилгээ эрхэлнэ.

"Дэлгэрэх" компани /УҮГ/ нь /цаашид компани гэх/ байгуул-  
лага, аж ахуйн нэгж, ард иргэдийг чанар сайтай өргөн хэрэглээ-  
ний бараа, үйлдвэрлэл үйлчилгээгээр хангах зорилгоор гадаад  
худалцаа, зуучлал, бараа солилцоо, борлуулалт, чөлөөт валютын  
худалцаа, жижиг үйлдвэрлэл /хүнс, үйлдвэрийн барааны/ үйлчил-  
гээг хүн амын хэрэглээний зориулалтаар явуулна. Компани нь  
үйл ажиллагаагаа өргөн явуулахын тулд салбар нэгжүүттэй байж  
дараах чиглэлээр ажиллана. Үүнд:

-Барааны мэдээллийн алба ажиллуулах зах зээлийг суллан  
бараа түүхий эдийг экспортлох, импортлох, реэкспортлох, зууч-  
лах үйл ажиллагаа явуулна.

-Барааны бирж ажиллуулан үнэ хаялцуулах, бөөнөөр худалдаа-  
лах, үзэсгэлэн, яармаг худалцаа ажиллуулах.

-Орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, ашигт ажиллагааг цээш-  
лүүлэх зорилгоор хүнсний бүтээгдэхүүний жижиг үйлдвэрлэл-үйл-  
чилгээ явуулах.

-Гадаадын болон бусад аж ахуйн нэгж иргэдтэй хамтран хө-  
рөнгө оруулалт хийж бараа худалдааны үйлчилгээг нээж ажиллуу-  
лах.

-Борлуулалт, арилжаа солилцооны үйл ажиллагаанд оролцогч  
компанийн ажилтан жарын ажлын арга технологи, хэлний боловсро-  
лыг цээшлүүлэхэд сургах, брокер маркетинг, биржийн ажилтан  
менеджерүүдийг бэлтгэх.

-Компанийн харилцагч этгээдийн хоорондын үйл ажиллагааг  
зохицуулах эрхийн үндэслэл нь харилцан үүрэг, эдийн засгийн

## 2.

хариуцлагыг тодорхойлох аж ахуйн гэрээ байна. Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн I-р сарын I-нээс 12-р сарын 31-нээр тасалбар болж байна.

"Дэлгэрэх" /УҮГ/ нь өөрийн дүрмийн сан 1814,3 мянган төгрөгийн эд хөрөнгөөр төрийн өмнө хариуцлага хүлээнэ. Компанийн сангуудыг байгуулах, зарцуулах журмыг компанийн зөвлөлийн хурлаар батлана.

Компани нь тогтоосон журмын дагуу улсын төсөвт татвар төлнө. Нийгмийн цаатгалын шимтгэлд цалингийн сангаас орлогын 13,5 хувийг улсад төлнө.

Компанийн нэвэр ашгийг тухайн санхүүгийн жилд орсон бүх орлого, гарсан зарлын ялгавраар тодорхойлно.

"Дэлгэрэх" /УҮГ/ нь улсын бүртгэлд бүртгүүлэн гэрчилгээ авснаар хуулийн этгээцийн эрх эцлэн үүрэг хүлээнэ. Компани нь банк, санхүү статистикийн байгууллагад тогтоосон журмын дагуу мэдээ тайлан гаргаж үйл ажиллагааныхаа үр дүнг жилд I удаа хэвлэн нийтлүүлнэ. Компани болон салбар нь өөрийн нэр бүхий тамга, тэмдэг /салбар нь тэмдэг/ албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

"Дэлгэрэх" /УҮГ/ нь үйл ажиллагаандаа БНМУ-ын аж ахуйн нэгжийн тухай хууль, компанийг байгуулсан гэрээ, энэхүү дүрмийн заалтыг уцирлага болгон ажиллана.

#### Хоёр. Удирдлага зохион байгуулалт.

"Дэлгэрэх" /УҮГ/-ийн эрх барих байгууллага нь бүх гишүүдийн хурал юм. Бүх гишүүдийн хурлыг жилд нэгээс доошгүй удаа хийж компанийн гишүүн бүр санал оруулах эрхтэй. Бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд захирлын өгсөн хувилбарыг үндэслэн шийдвэрлэнэ. Хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

"Компанийн тайлан тэнцэл, ашиг хуваарилалт, орлого зарлагын төсөв батлах.

-Компанийг өөрчлөн байгуулах /нийлүүлэх, нэгтгэх, салгах тусгаарлах/ үйл ажиллагааг нь зогсоох.

## 3.

- Гэрээ дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах.
- Гэрээнд заасан бусад зүйлийг хэлэлцэх.

Бүх гишүүдийн хурлын чөлөө цагт "Дэлгэрэх" /УУГ/-ийг хотын Арлын Хурлын гүйцэтгэх захиргааны шийдвэрээр томилогдсон захирагч удирдана. Захирал компанийг төлөөлөх ба захирлаас бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр бусад гишүүд төлөөлж болно.

Захирал нь гишүүдийн бүртгэл хөтөлж, хөрөнгийн тооцоо хийж, тайлан тэнцлийг гарган компанийг өдөр тутмын удирдлагаар хангана. Ажлаа бүх гишүүдийн хуралд тайлагнана.

Захирал дор дурдсан эрх үүрэгтэй.

-Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, компанийн зөвлөлийн хурлын шийдвэр болон энэхүү дүрмийн биелэлтийг хариуцаж компанийн үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар тушаал гаргана.

-Компанийг төлөөлж ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажилд томилох, халах, шагнах арга хэмжээ авах.

-Компанийн тайлан тэнцэл болон ашиг орлого, хэтийн төлөв чиглэлийн талаар санал боловсруулж компанийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

-Компаниас гаргасан тайлан мэдээний үнэн зөвийг хариуцан үндсэн болон эргэлтийн хөрөнгийг захиран зарцуулна.

-Компанийг төлөөлж аж ахуйн нэгжүүд иргэд, гадаадын хуулийн этгээцтэй гэрээ хэлэлцээр байгуулна.

-Компанийн зөвлөлөөс баталсан орон тоо, цалингийн сан, зардлын төсвийг үндэслэн ажилчид, менежер, удирдах ажилтны тооны харьцааг баримтлан компанийн зохион байгуулалтанд өөрчлөлт оруулах, албан тушаалтны цалинг тогтоож батална.

Гурав. Гишүүний хурал, эрх, хариуцлага

"Дэлгэрэх" /УУГ/-ийн гишүүн нь:

-Компанийн бүх үйл ажиллагаанд оролцох.

-Компанийн гишүүн нь БНМАУ-ын аж ахуйн нэгжийн хуулийн 4-р бүлгийн 25-р зүйлд дурдсан эрх, үүргийг хүлээнэ.

-Компанийн гишүүн нь энэхүү дүрмээр олгогдсон үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд биечлэн оролцохын зэрэгцээ худалдаа, үйлчил-

115

5.

чилгээг өргөтгөх, компанийн санхүүжилт, үйл ажиллагааны талаар бэригтлэх санал хүсэлтээ илэрхийлэх эрхтэй.

#### Дөрөв. Компанийн хяналт шалгалт

-Компанийн үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор шалган байцаах комиссыг байгуулна.

-Шалгалтад шаардагдах материалыг компани гаргаж өгнө.

-Шалган байцаах комисс нь шалгалтын үр дүнг бүх гишүүдийн хуралд оруулна.

-Захирлын бусадтай хийсэн гэрээ, хэлэлцээтэй холбогдсон маргааныг шүүх хянан шийдвэрлэхэд Шалган байцаах комиссоос томилсон комиссын гишүүн нь компанийг төлөөлөн оролцох эрхтэй.

#### Тав. Бусад зүйл

Компаниас бусад хуулийн этгээдтэй үүссэн маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ. Хамтарсан компани, үйлдвэр гадаадын хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний тухайд маргааныг гэрээнд өөрөөр заагаагүй бол БНМАУ-ын шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

Компанийн үйл ажиллагааг БНМАУ-ын хууль тогтоомжид заасан нөхцөлөөр зогсоож болно.

Компанийн үйл ажиллагааг зогсоосон тухай хэвлэлээр мэдэгцэнэ.

Улаанбаатар хотын Ардын Хурлын  
 гүйцэтгэх захиргааны 1991 оны  
 338 дугаар тогтоолын 2 дугаар  
 хавсралт

**"ДЭЛГЭРЭХ" КОМПАНИ /УУХ/-ИЙН САЛБАР  
 ДЭЛГҮҮРТ БАРАА ХҮЛЭЭН АВАХ, ХУДАЛ-  
 ЦААЛАХ ДҮРЭМ**

1. Дэлгүүрт шинэ болон иргэдийн эцэлж хэрэглэсэн, цаашид хэрэгцээ хангахуйц өргөн хэрэглээний бүх төрлийн хүнс, үйлдвэрийн бараа, үслэг эцлэл, ангийн үс, алт, мөнгөн чулуун эцлэл /сорьц тогтоогдсон/ хүлээн авах.

2. Шүүх, барааны зах, сэргийлэхийн журмаар хураагдсан улсын орлогын бараа эд юмсыг хүлээн авч худалцаалах.

3. Барааг хүлээн авахдаа иргэний паспорт, үнэмлэхийг баримтлан маягт бүртгэлд бүрэн гүйцэд тусган, барааны нэр төрөл, тоо хэмжээ, марк, шинж чанар, өнгө элэгдэл, гэмтэл соргог болон шариин механизм, техникийн барааг цагалцах баримтыг үнцэслэн хувийн дугаар, үйлдвэрлэсэн он, цагалдах эц анги, иж бүрдэл зэргийг тодорхой бичих.

4. Дэлгүүрт шимтгэлтэйгээр тавьж худалцаалах барааг барааны мэргэжилтэн нэг бүрчлэн шалгаж үнэлэн маягт № 1-ийг бэлэн үнээр хүлээн авах барааг нэг бүрчлэн тоо, чанарын шалгалт хийсний дараа маягт № 3-ыг шимтгэлтэй болон бэлэн үнээр хугацаандаа борлогдоогүй бараанд маягт № 10 барааг буцааж олгоход маягт № 2-ыг тус тус бичих. Барааг бэлтгэн нийлүүлэгчээс хорогцлын хувь хэмжээг харилцан тохиролцонд авахдаа бараа материал хүлээн авах акт ХБЯ маягт № 96-г хөглөх, бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээ протокол үйлцэн барааны үнийг борлуулсаны дараа болон урьдчилан төлбөрийн тооцоог хийж бараа хүлээн авч борлуулах.

5. Аж ахуйн нэгж хувь хүмүүсийн хооронд худалдаа хийж, овор ихтэй хашаа байшин, тээврийн хэрэгсэл зэрэг зүйлийг худалдах хүмүүсийн захиалтыг хүлээн авч зуучлалын үүрэг гүйцэтгэх.

6. Худалдаанд барааг 20 хоногийн хугацаатай хүлээн авах бөгөөд элэгцлийн хэмжээ бэлэн кувцас, оёмол, сүлжмэл, ноосон эцлэл, гуталц 20%, цахилгаан техникийн барааны 50 хувиас хэтрэхгүй байх.

7.Балэн үнээр барааг хүлээн авахдаа зах зээлд борлогдох байдал, зах зээлийн үнэ эрэлт харагцээтэй уялдуулан авах, чанар байдлаа адисан, түргэн гэмтэх иж бүрдэлгүй нэг нар төрлийн гүйлдгээ удаан борлолттой барааг хэт олноор авч хямдруулан аллагдлаа гаргасан менежертэй ажлын хариуцлагыг хууль тогтоомжинд зааснаар тооцох.

8.Бордуулахаар хүлээн авсан бараа нэг бүрт үнийн хаяг зүүж, ломбоцон бараа хүлээн авснаас хойш 46 цагийн дотор худалдаанд гаргах.

9.Худалдаанд тавигдсан бараанаас аж ахуйн нэгжийн хүсэлтийг харгалзан балэн бус тооцоогоор /шилжүүлгээр/ худалдаа хийх

ХОЁР.Барааны үнийг хямдруулах барааг  
буцаан олгох

10.Иргэдээс худалдуулахаар тавьсан бараа анхны тохиролцсон үнээр 20 хоногийн хугацаанд борлогдохгүй болунийг 20 хувиар хямдруулж худалдаадах. Хэрэв үнэ хямдруулахыг эзэн зөвшөөрөхгүй бол буцааж олгох. Хэрэв эзний саналаар тогтоосон хугацаа, хувийг харгалзахгүйгээр барааны үнийг хямдруулах.

11.Барааны үнийг чөлөөтэй тогтоох, үнэ хямдруулах асуудлыг байгууллагад ашигтайгаар шийдвэрлэх эрхийг компанийн менежерүүдэд олгож үр пүнг улирал тутам хэлэлцэж байх.

12.Шна хямдруулснаас хойш 15 хоногийн дотор борлогдохгүй барааг эзэнд нь эргүүлж өгөх. Эзэн нь буцааж авахгүй 3 сар болсон барааны үнийг барааны чанар, гүйлдгээг харгалзан 50 хүртэл хувиар үнийг 2 дахь удаагаа хямдруулах

13.Хүлээн авсан бараа нь 2 дахь удаагаа үнэ хямдраад борлогдохгүй эзэн нь буцааж авахгүй 3 сараас дээш болвол аль борлогдох үнээр дахин үнэлж хямдруулах.

14.Огт борлогдохгүй, эзэн нь буцааж авахгүй 6 сараас дээш болсон барааг комисст акт тогтоож, хоёрдогч түүхийг энээр ашиглах, актанд устгах зэрэг арга хэмжээ авах.

15.Худалдагдсан барааны үнийг нэг жилийн дотор авахгүй бол улсын орлогод оруулж данс бүртгэлд тооцох.

16.Балэн үнээр авсан бараа нь нэг сарын дараа болон цаашид анхны чанар байдлаа алдаж борлогдохгүйг хүрвэл үнийг хямдруулахаа тохиролцоогоор худалдан авсан анхны үнэ хүртэл хямдруулах.

3.

17. Анх авсан тохиролцооны үнээрээ борлогдохгүй 3 сараас дээш болбол уг барааг хүлээн авсан барааны мөргөжилтэн хариуцаж дэлгүүрийг тохиролгүй болгож асуудлыг шийдвэрлэх.

Гурав. Компанийн салбар дэлгүүрт ажиллагааны орлого, шимтгэлийг тооцох.

18. Дэлгүүр нь /орлого/ шимтгэлд худалдуулахээр тавьсан бараа анхны 20 хоногийн хугацаанд борлогдвол барааны үнийн дүнгээс иргэдээс 8 хүртэл хувийн шимтгэл авна.

19. Үнэ хямдарч, хугацаанаасаа хатарч борлогдсон барааны үнийн дүнгээс 2 хувийн шимтгэлийг 32 дугаарт заасан хувь дээр нэмж авна.

20. Борлогдоогүй буцаасан барааны үнийн дүнгээс 3 хувийн үйлчилгээний шимтгэл авна.

21. Гааль, саргийлах, шүүхийн байгууллагаас улсын орлогод ирүүлсэн, албан газруудаас өгсөн барааны борлолтоос 8 хувийн шимтгэл авна.

22. Албан байгууллага, иргэдийн хооронд зуучлан бэлэн бус тооцоогоор худалдсан, барааны үнийн дүнгээс 15 хувийн хүртэл шимтгэл тохиролцон авна.

23. Барааны үнийг дэлгүүрийн санхүүгээс борлогдсоноос хойш төрөл бүрийн гутал, бэлэн хувцас, жижиг бараа, гар ахуйн барааны үнийг 2 хоногийн дараа цахилгаан техникийн барааны үнийг 5 хоногийн дараа олгоно. Барааны үнийг долоо хоногт 3 өдөр тогтмол өгнө. Улсын орлого ба албан газруудын барааны үнийг цаг тухайд нь тооцож зохих газруудад төлнө.

Дөрөв. Дэлгүүрт барааг хүлээн авах, худалдаалахад хоригдох зүйл

24. Төрөл бүрийн халуун хүйтэн зэвсэг, химийн, хортой бодис, сорьц нь тогтоогдоогүй алт, мөнгөн эдлэл.